МОНГОЛ УЛСЫН
ЭРҮҮЛ МЭНДИЙН САЙДЫН ТУШААЛ

2016 оны 12 сарын 16 өдөр Дугаар А/190 Улаанбаатар хот

Эм зүйн салбарын сайн засаглалын
удирдамж батлах тухай

Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 24.2, Эрүүл мэндийн тухай хуулийн 26 дугаар зүйлийн 26.1, 26.2, Төрөөс эмийн талаар баримтлах бодлогын 9.2 дахь заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. “Эм зүйн салбарын сайн засаглалын удирдамж”-ыг хавсралтаар батлсугай.

2. Тушаалын хэрэгжилтийг хангаж ажиллахыг Эрүүл мэндийн хөгжлийн төв /Б.Нарантуяа/-д үүрэг болгосугай.

3. Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Эм, үйлдвэрлэл, технологийн газар /Л.Мөнхтулга/, Эмнэлгийн мэргэжилтний ёс зүйн хяналтын хороо /Б.Саранцэцэг/-д тус тус үүрэг болгосугай.

САЙД А.ЦОГЦЭЦЭГ

080771

Эрүүл мэндийн сайдын 2016 оны
12 дугаар сарын 16..-ны өдрийн
А/190 дугаар тушаалын хавсралт

# ЭМ ЗҮЙН САЛБАРЫН САЙН ЗАСАГЛАЛЫН УДИРДАМЖ

## Нэг. Нийтлэг үндэслэл

1.1. Эм зүйн салбарын сайн засаглалын удирдамж нь ёс суртахууны үнэт зүйл, ёс зүйн зарчим дээр тулгуурлана.

1.2. Энэхүү удирдамж нь Эрүүл мэндийн тухай хууль, Эм, эмнэлгийн хэрэгслийн тухай хууль, Авлигын эсрэг хууль, Ашиг сонирхлын зөрчлийн тухай хуулийн хүрээнд мөрдөгдөнө.

1.3.Эм зүйн салбарын сайн засаглалын удирдамж нь эрүүл мэндийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны, мэргэжлийн хяналтын болон хувийн хэвшлийн эрүүл мэндийн байгууллагын үйл ажиллагаандаа мөрдөх ёс зүйн үндсэн баримт бичиг болно.

## Хоёр. Эм зүйн салбарт сайн засаглалыг бэхжүүлэх зорилго

2.1.Хүн амыг аюулгүй, чанартай, эмчилгээний өндөр идэвхтэй, боломжийн үнэтэй эмээр жигд, хүртээмжтэй хангаж, эмийн зохистой хэрэглээг төлөвшүүлэхэд эм зүйн салбарын үндсэн үйл ажиллагаа болох эмийг бүртгэх, сонгох, худалдан авах, түгээх, хянаж шалгах, тусгай зөвшөөрөл олгох, зах зээлд таниулахад мөрдөх ёс зүйн зарчмыг тодорхойлон, оролцогч талуудад хариуцлагатай шударга, ил тод байдлыг төлөвшүүлэхэд энэхүү удирдамжийн зорилго оршино.

## Гурав. Эм зүйн салбарын сайн засаглалын удирдамжийн зорилт, хамрах хүрээ

3.1.Эм зүйн салбарын сайн засаглалын удирдамж дараах зорилттой:

3.1.1.эм зүйн салбарын төр болон хувийн хэвшилд ажиллаж буй албан хаагч, эмнэлгийн мэргэжилтэнд шударга, ил тод, хариуцлагатай байдал, ёс зүйтэй үйл ажиллагааг төлөвшүүлэх;

3.1.3.эм зүйн салбар дахь авлигыг бууруулах мэдлэгийг сайжруулах;

3.1.4.эм зүйн салбарт сайн засаглалыг хэрэгжүүлэх.

**Дөрөв. Сайн засаглалыг төлөвшүүлэхэд баримтлах үндсэн зарчим**

4.1. Бие даасан хараат бус байх:

4.1.1.байгууллага нь өөрийн үйл ажиллагаанд баримтлах эрхэм зорилго, алсын харааг тодорхойлсон байх ба албан хаагч, удирдлага нь холбогдох хууль тогтоомжын хүрээнд ажиллан, хууль бус гадны нөлөөлөл, урамшууллын сэдэл, дарамт шахалт, хөндлөнгийн оролцоо, шалтгаанаас ангид байх.

4.2.Үр нөлөөтэй байх:

4.2.1.байгууллагын удирдах ажилтан, ажилтан, мэргэжилтэн, зөвлөлийн хорооны үйл ажиллагаа, үүрэг хариуцлага тодорхой байх ба төрийн байгууллага нөөцийг нийгмийн эрэлт хэрэгцээнд тулгуурлан нийгмийн хяналтан дор хамгийн үр ашигтай, үр дүнтэй зарцуулах.

4.3.Шударга байх:

4.3.1.төрийн албан хаагч нь хуулийн хүрээнд эрх, үүргээ шударгаар хэрэгжүүлэх.

4.4. Ил тодбайх:

4.4.1.нотолгоонд суурилсан мэдээллийг ашиглан шийдвэр гаргаж,холбогдох хууль тогтоомжийн хүрээнд хэрэгжүүлэх ба олон нийт, сонирхогч талуудыг ил тод, нээлттэй, мэдээллийг цаг тухайд авах боломжоор хангах.

4.5.Хариуцлагатай байх:

4.5.1.төрийн албан хаагч тухайн ажлыг гүйцэтгэхэд шаардагдах мэдлэг, чадвар, туршлагатай байж, байгууллагын үйл ажиллагаа шийдвэртэй холбоотой асуудлаар тайлагнаж, хариуцах чадвартай байх аливаа хяналт шалгалтаас зайлсхийх ёсгүй.

4.6.Оролцоог хангах, хүртээмжтэй байх:

4.6.1.оролцогч талууд төрийн тогтолцооны бүх түвшинд бодлого боловсруулах, шийдвэр гаргах үйл явцад мэдээлэлтэй оролцох, нөлөөлөх боломжтой байх ба тухайн байгууллага өөрийн зохион байгууж буй үйл ажиллагаандаа оролцогч талуудыг жигд оролцох боломжоор хангах.

**Тав. Эм зүйн салбарын сайн засаглалын бүрэлдэхүүн**

5.1. Эм зүйн салбарын сайн засаглал дараах бүрэлдэхүүн хэсгүүдтэй байна. Үүнд:

5.1.1.ёссуртахуунтэйүнэтзүйлс ба ёсзүйнзарчим, удирдамж;
5.1.2.ёс зүйн хэм хэмжээ;
5.1.3.ил тод, хариуцлагатай зохицуулалт ба удирдлагын үйл явц;
5.1.4.буруу үйлдлийг мэдээлэх механизм;
5.1.5.хариуцлагын арга хэмжээ;
5.1.6.авлигын эсрэг санаачлагатай хамтран ажиллах;
5.1.7.сайн засаглалыг хэрэгжүүлэх хүний нөөц.

**Зургаа. Ёс зүйгүй үйл ажиллагаа**

6.1. Эм зүйн салбарын үйл ажиллагааг хэрэгжүүлэх явцад үүсч байгаа дараах зөрчлийг ёс зүйгүй, авлигад хүргэх үйл ажиллагаа гэж үзнэ. Үүнд:

6.1.1.эм, эмнэлгийн хэрэгслийн тухай хууль, төрийн бодлого, холбогдох дүрэм, журмыг авлигын улмаас гуйвуулах;

6.1.2.эмийн бүртгэл, тусгай зөвшөөрлийн үйл явцыг зохиомлоор хурдасгах;

6.1.3.эмийг бүртгэх, тусгай зөвшөөрөл олгоход шаардагдах мэдээлэл хангалттай бус байхад эмийг бүртгэх, зөвшөөрөл олгох;

6.1.4.бүртгэл, тусгай зөвшөөрлийн үйл ажиллагааг удаашруулах;

6.1.5.зайлшгүй шаардлагатай эмийн жагсаалт болон эрүүл мэндийн даатгалаас хөнгөлөлттэй олгох эмийн жагсаалтад орсон эмийг урамшуулал авсаны үндсэн дээр сонгох;

6.1.6.эмийн чанарын хяналтын үр дүн, дүгнэлтийг нуун дарагдуулах, өөрчлөх;

6.1.7.эм үйлдвэрлэлийн зохистой дадал (GMP)-ын шаардлага болон бусад стандарт, журмыг хангаагүй байхад гэрчилгээ олгох;

6.1.8.эмийг хугацаанд нь ханган нийлүүлээгүй байгууллагатай хариуцлага тооцохгүй байх;

6.1.9.эмийн компанийн санхүүжилтээр, худалдааны зорилгоор хуурамч туршилт хийхийг зөвшөөрөх;

6.1.10.эмийн чанар, аюулгүй болон үр ашигтай байдлын талаар хуурамч мэдээ өгөх;

6.1.11.эмийн худалдан авалтад хамаарах нууц болон нэн чухал мэдээллийг тендерт оролцогчдод хаалттайгаар дамжуулах, хуйвалдах;

6.1.12.ажил хэргийн туслалцаа авах зорилгоор хувь хүнд сайн дураараа мөнгө төлөх;

6.1.13.эм ханган нийлүүлэх гэрээ олж өгөх;

6.1.14.хувийн хэрэглээ, хувийн салбарт дахин борлуулах зорилгоор эмийн хулгай хийх;

6.1.15.хандив тусламжаар орж ирсэн болон үнэгүй олгох нөхцөлтэй эмийг зарж ашиг олох;

6.1.16.худалдан авах үйл ажиллагаа болон үнэ тогтооход хуйвалдах;

6.1.17.эм, эмнэлгийн хэрэгслийн үнийг хэт хөөрөгдөх, үгсэн хуйвалдаж үнийг өсгөх;

6.1.18.өөрийн төрөл төрөгсөд, найз нөхдийг албан тушаал, шийдвэр гаргах хороо, зөвлөлийн гишүүнээр томилох;

6.1.19.өөрийн төрөл төрөгсөд, найз нөхдийн бизнесийн үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлэх.

**Долоо. Ёс зүйн үнэт зүйлс**

7.1. Төрийн албан хаагч өөрийн үйл ажиллагаандаа ёс суртахууны үнэт зүйлийг мөрдөж, ёс зүйгүй зан үйлээс сэргийлэн, авлигаас ангид байна.

7.2. Байгууллага нь ажлын үр дүнг нэмэгдүүлэх зорилгоор төрийн албан хаагчдад нэгдүгээр хавсралтад заасан ёс зүйн зарчмыгмөрдүүлнэ.

7.3. Эм зүйн салбарын албан хаагч үйл ажиллагаандаа дараах үнэт зүйлсийг төлөвшүүлнэ:

7.3.1 Ашиг сонирхолын зөрчилгүй ажиллах: Албан үүргээ шударгаар гүйцэтгэхэднөлөөлөх эдийн засгийн сонирхолоос ангид байж, тодорхой нэг хувийн байгууллага, хувь хүнд давуутай хандлага үзүүлэлгүйгээр зөвхөн нийтийн ашиг сонирхолд нийцсэн,санхүүгийн болоод материаллаг бусад сонирхолын үүднээс ангид шийдвэр гаргана.

7.3.2 Зарчимч байх: Төрийн албанд ажиллагсад олон нийт болон хамт ажиллагсадынхаа эрхийг хүндэтгэж, хууль, ёс зүйн зарчмыг зөрчих аливаа үйлдлээс зайлсхиж, албан үүрэгтээ сөргөөр нөлөөлж болох санхүүгийн болон бусад амлалт үүргийгхувь хүн, байгууллагын өмнө хүлээх ёсгүй.

7.3.3 Бодитой хандах:Хувь хүнийг албан тушаалд томилох, гэрээ хэлэлцээр байгуулах, шагнал урамшуулал, тэтгэлэгт тодорхойлоход зөвхөн уг ажил, үйлчилгээг гүйцэтгэх чадвар, гавъяа зүтгэлд нь үндэслэнэ.

7.3.4 Хариуцлагатай байх: Төрийн албан хаагч үйл ажиллагаа, гаргасан шийдвэрийнхээ төлөө олон нийтийн өмнө хариуцлага хүлээж, аливаа хяналт шалгалтаас зайлсхийх ёсгүй. Олон нийтийн бус байгууллагын мэдээллийг эдийн засгийн зорилгоор өөрийн хувийн сонирхолд нийцүүлэн зүй бусаар ашиглахгүй байна.

7.3.5 Ил тод байх: Төрийн албан хаагчдын гаргаж байгаа шийдвэр, хэрэгжүүлж буйүйл ажиллагаа ил тод байна. Гаргасан шийдвэрийнхээ үндэслэлийг олон нийтэд ил тод мэдээлдэг, мэдээллийг зөвхөн нийтийн ашиг сонирхолд илэрхий харшилсан тохиолдолд хязгаарладаг байна.

7.3.6 Шударга байх: Төрийн албан хаагч нийтийн ашиг сонирхолыг хамгаалах үүднээс албан үүрэгт нь харшлах хувийн сонирхолынхоо талаар мэдээлж, ашиг сонирхолын зөрчилгүй ажиллаж, ёс зүйгүй зан үйл, авлигыг илрүүлэх, өөрийн хувийн үйлдлээрээ байгуулагынхаа нэр төрд муугаар нөлөөлөхгүй байна.

7.3.7 Манлайлах: Төрийн албан хаагч сайн засаглалыг төлөвшүүлэх, ёс зүйн зарчмыг мөрдөхөдманлайлал, үлгэр дууриалал үзүүлнэ.

## Эм зүйн сайн засаглалын ёс зүйн зарчмын хамрах хүрээ

### 1.Эмийн бүртгэл

Эмийн бүртгэл нь: чанартай, үр ашигтай, аюулгүй эмийг бүртгэх үйл ажиллагаа юм.

| № | Үйл ажиллагаа | Үйл ажиллагааны үе шат | Өртөмтхий үзүүлэлт | Ёс зүйн зарчим | Ёс зүйн алдаа гаргахаас сэргийлэх |
|---|---|---|---|---|---|
| 1 | Бүртгэлийн материалыг хянахаар сонгох | Бүртгэлийн материалыг шалгуурт нийцэж байгааг үнэлүүлэх зорилгоор шинжээчид өгөх | дараалал алгасах, давуу хандлага гаргах, удаах, буруу харьцах | • Мэдлэг<br>• Чадвар<br>• Ур чадвар<br>• Бодит<br>• Гярхай<br>• Оновчтой<br>• Шударга<br>• Хуулийг баримтлах<br>• Зарчимч<br>• Задлан шинжилдэг<br>• Хариуцлагатай<br>• Ашиг сонирхолын | • Эрх мэдлээ буруугаар ашиглах<br>• Мэргэжлийн үүрэг хариуцлагаа үл ойшоох<br>• Дарамтанд бууж өгөх<br>• Ашиг сонирхолын зөрчилтэй байх<br>• Шийдэмгий бус үйлдэл |
| 2 | Бүтээгдэхүүний чанар, үр ашигтай болон аюулгүй байдлыг үнэлэх | Бүтээгдэхүүний мэдээллийг хүлээн авах | бүрэн бус, алдаатай, хуурамч өгөгдөл | | |
| | | Удирдамж, журам, цагийн хуваарь, үйлчлүүлэгчийн дүрэм | баримтлахгүй байх | | |
| | | Шинжээчийн хараат бус байдал | хуулиар зөвшөөрөгдсөн ашиг сонирхол, хөнгөлөлт үзүүлэх, мөнгө, бэлэг, хандив болон бусад зүйлээр нөлөөлөх | | |
| | | Нотолгоонд суурилсан үнэлгээ | бүртгэх шийдвэр гаргахад нөлөөлөх чухал мэдээллийг үгүйсгэх | | |
| 3 | Бүтээгдэхүүний г бүртгэхээр шийдэх эсвэл татгалзах | Хүсэлтийг зөвшөөрөх эсвэл татгалзах эрх | хууль ёсны сонирхолтой талын нөлөөлөлд өртөх | | |
| | | Хороо, зөвлөлийн гишүүдийг сонгох | найз нөхөд, төрөл садангаа сонгох | | |
| | | Хороо, зөвлөлийн үүрэг хариуцлагыг тодорхойлсон үйл ажиллагааны журам | хууль ёсны сонирхолд тохируулахын тулд заль гаргах | | |
| | | Ашиг сонирхолын зөрчлийн мэдүүлэг | худлаа мэдүүлэг гаргах | | |
| | | Хороо, зөвлөл шийдвэр гаргах процесс | тодорхой удирдамжгүй, ил тод бус | | |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| | | Хороо, зөвлөлийн шийдвэр | дарамт, нөлөөлөлд өртөх | | |
| | | Хороо, зөвлөлийн шийдвэрийг түгээх | саатуулах, удаашруулах, сонирхогч талуудад мэдээлэхгүй байх, шийдвэрийг цаг хугацаанд нь хүргэхгүй байх | | |
| | | Хороо, зөвлөлийн шийдвэрийн үндэслэлийг гаргах | татгалзах | | |
| | | Хороо, зөвлөлийн шийдвэрийн эсрэг гомдол гаргах | ил тод бус, заль мэх гаргах, мэдээлэлгүй байх, удаах | | |
| 4 | Зөвшөөрсөн бүтээгдэхүүний г бүртгэх | Бүртгэлийг цаг хугацаанд нь зөв мэдээллээр шинэчлэх | удаах, саатуулах, ил тод бус, буруу | | |
| 5 | Бүтээгдэхүүний бүртгэлийн гэрчилгээ олгох | Холбогдох бичиг баримтыг зөв, нягт нямбай мэдээлэл дээр тулгуурлан гаргах | бичиг баримтанд буруу мэдээлэл оруулах, саатуулах, удаашруулах | | |
| | | Цаг хугацаанд нь олгох | | | |
| | | Бичиг баримтыг эрх бүхий этгээдэд өгөх | | | |
| 6 | Сонирхогч талууд болон олон нийтэд мэдээлэл өгөх | Эмийн бүртгэлийн үйл явц, Хороо, зөвлөлийн гишүүдийн жагсаалт, бодлого, бүтээгдэхүүний зөвшөөрөл, аюулгүй байдал болон чанар, бүртгэлээс хасах, хариуцлага тооцох үйл явц, хуурамч бүтээгдэхүүнтэй холбоотой бичиг баримт, удирдамж гаргах | худлаа мэдээлэл, саатуулах, удаашруулах, заль гаргах, сонгох | | |
| | | Мэдээлэл хамгийн сүүлийн үеийн, нягт нямбай, цаг үеийн байна | | | |

## 2.Үйлдвэрлэгч, ханган нийлүүлэгч, эмийн сангийн хяналт шалгалт, тусгай зөвшөөрөл, лиценз

Үйлдвэрлэгч, ханган нийлүүлэгч, эмийн сангийн хяналт шалгалт нь эм хангамжийн байгууллагууд үндэсний стандарт, бусад баримт бичигт нийцсэн эмийг үйлдвэрлэж, хадгалж, ханган нийлүүлж байгааг батлаж чадах эмийн зохицуулалтын чухал чиглэл юм.

| № | Үйл ажиллагаа | Үйл ажиллагааны үе шат | Өртөмтхий үзүүлэлт | Ёс зүйн зарчим | Ёс зүйн алдаа гаргахаас сэргийлэх |
|---|---|---|---|---|---|
| 1 | Үнэлгээ, хяналт шалгалт хийх | Үнэлгээг товлох | дараалал алгасах, давуу хандлага гаргах, удаах, буруу харьцах, | Нууцыг хадгалах<br>Үр дүнтэй<br>Ил тод<br>Мэдлэг<br>Чадвар<br>Ур чадвар<br>Бодит<br>Гярхай<br>Оновчтой<br>Шударга<br>Хуулийг баримтлах<br>Зарчимч<br>Задлан шинжилдэг<br>Хариуцлагатай<br>Ашигсонирхолын зөрчилгүй | • Өөрийн эрх, хэрэгцээ, хүсэл, үзэл бодол, мэдрэмжээ илэрхийлэхдээ алдаа гаргах<br>• Шийдвэр гаргахаас өмнө дэмжлэг авах<br>• Шийдвэрээ буцаах |
| | | Баг болон байцаагчийг сонгох давтан үнэлэх бол шинжээч болон байцаагчийг солих | Танил тал, төрөл саднаа сонгох | | |
| | | холбогдох тушаал зааврыг сайтар ойлгож танилцан үнэлгээний төлөвлөгөөг гаргах | Тушаал шийдвэрийг мөрдөхгүй байх | | |
| | | Үнэлэх шалгуурыг стандарт шаардлагын дагуу боловсруулах, | үнэлгээний шалгуур оновчтой биш байх, шалгуур боловсруулах чадвар мэдлэг дутмаг | | |
| | | Байгууллагын үнэлгээг хийх, илэрсэн зөрчлийг эрсдэлээр нь ангилах | Үнэлгээг бодитой бус хийх, ашиг сонирхлын зөрчил гаргах, дарамтлах, буруу үнэлэх, хээл хахууль авах, ялгаварлах, нууцыг задруулах, харилцаа тогтоох, багийн удирдагч, шийдвэр гаргагчийн нөлөөлөл, дарамтад орох | | |
| 2 | Хяналт, шалгалт, үнэлгээний дүгнэлтийг танилцуулж шийдвэр гаргах | Хяналт шалгалтын дүнг холбогдох комисс зөвлөлд танилцуулах, тайлан бичих | Зөрчлийг нуун дарагдуулах, хариуцлагагүй хандах, дүгнэлт ил тод бус | | |
| | | Тусгай зөвшөөрлийн комисс шийдвэр гарган, тусгай зөвшөөрлийг олгох | Шийдвэр тэнцвэртэй бус байх, бодитой биш байх, шийдвэр нь хууль тогтоомж зөрчсөн байх, | | |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| | | | дүгнэлтэд үндэслээгүй байх, хээл хахууль авах | | |

### 3.Эмийг зах зээлд таниулах, идэвхжүүлэх

Үйлдвэрлэгч, ханган нийлүүлэгчийн эмийг зах зээлд таниулах үйл ажиллагаа нь жор бичилт, эмийн хангалт болон худалдан авалтанд нөлөөлдөг. Эмийг зах зээлд таниулах үйл ажиллагааг хянах нь бодит мэдээллийг эрүүл мэндийн тусламж үзүүлэгчдэд өгөх, тэднийг материаллаг урамшууллын нөлөөнд орохоос урьдчилан сэргийлэх зорилготой юм.

| № | Үйл ажиллагаа | Өртөмтхий үзүүлэлт, хориглох үйлдэл | Ёс зүйн зарчим |
|---|---|---|---|
| 1 | Худалдааны төлөөлөгчийн эмийг зах зээлд таниулах үйл ажиллагаанд хамрагдах, компаниас хандив авах | • Хууль, дүрэм, заавар, стандартыг мөрдөхгүй байх<br>• Ашиг сонирхолын зөрчил<br>• Буруу мэдээлэл өгөх<br>• Шийдвэр гаргалт ил тод бус<br>• Ялгаварладаг<br>• Хариуцлагагүй<br>• Давуу байдал үзүүлэх<br>• Хээл хахууль бэлэг авах<br>• Залилах, хуурах<br>• Улс төрийн болон удирдлагын дарамт<br>• Эрх мэдлээ хэтрүүлэн буруугаар ашиглах | • Баталгаатай мэдээлэлд үндэслэх<br>• Ёс суртахууны үнэт зүйлийг ойлгох<br>• Ашиг сонирхолын зөрчилгүй<br>• Ялгаварладаггүй<br>• Мэдлэг, мэргэжлээ дээшлүүлэх<br>• Тэнцвэртэй<br>• Шударга<br>• Ил тод<br>• Хариуцлагатай<br>• Нууцыг хадгалах |
| 2 | Хэвлэл мэдээллийн хэрэгслээр явуулах зар сурталчилгаа, хандивын үйл ажиллагаа болон олон нийтийн дүрс зургийг /public icon/ ашиглах | | |
| 3 | Зөвшөөрөгдсөн зар сурталчилгааг явуулах | | |
| 4 | Зар сурталчилгаа, холбогдох баримт бичгийг хянаж, зөвшөөрөл олгох | | |

### 4.Сонголт, клиник туршилт

Эмийг зөв сонгож эмийн лавлах, жагсаалтад оруулах нь худалдан авах ажиллагаанд суурь нь болж өгдөг.

| № | Үйл ажиллагаа | Үйл ажиллагааны үе шат, нотолгоо | Өртөмтхий үзүүлэлт | Холбогдох ёс зүйн зарчим |
|---|---|---|---|---|
| 1 | Хүсэлтийн маягт бэлтгэх, | Нотолгоонд суурилсан клиникийн баримт материалыг санал болгож танилцуулах | • Эмийн компаниуд сонгох эмийг шийдэх, эмч нарт маягт бэлтгэж өгөх | • Олоннийтийнаши гсонирхолынтөлө |

| | | | | |
|---|---|---|---|---|
| | туршилтын зөвшөөрөл хүсэх | Арга зүй болон бусад холбогдох материалыг бүрдүүлж өгөх | • Төсөв, эмэнд тавих шаардлага, өвчлөл, өвчний хүндрэлийг харгалзан үздэггүй<br>• Хорооны гишүүдэд эцсийн шийдвэр гаргахад нөлөөлөх<br>• Дээж өгч эмийг хэрэглүүлэх эрчимтэй идэвхжүүлэлт<br>• Эмийн чанар, аюулгүй болон үр ашигтай байдлын талаарх клиникийн өгөгдөхүүнийг хуурамчаар өгөх эсвэл орхих<br>• Мэргэжилтнүүдэд үнэгүй дээж өгөх нь замбараагүй хэрэглээнд хүргэнэ<br>• Эрчимтэй идэвхжүүлэлт зохисгүй жор бичилтэнд хүргэнэ<br>• Худалдааны зорилтонд хүргэх зах зээлийн стратеги<br>• Шагнал урамшуулал<br>• Бэлэг<br>• Хандив (аялал, хурал, семинар)<br>• Зөвлөх/мэргэжилтэнд маягтан дээр гарын үсэг зурсны төлөө өгөх төлбөр<br>• Компаний дарамт<br>• Үйл явцыг хурдасгах<br>• Бүтээгдэхүүнийг дэмжихийн тулд нотолгоонд суурилаагүй хэвлэлийн материалыг хүлээн зөвшөөрөх<br>• Зохих мэдлэг, сургагдаагүй хүнийг үнэлгээнд оролцуулах | ө үрашигтай, үрбүтээлтэй үйлчилгээ<br>• Үр бүтээлтэй<br>• Цаг үеэ мэдрэх<br>• Найдвартай<br>• Ашиг сонирхолын зөрчилгүй<br>• Мэдлэгтэй<br>• Ялгаварладаггүй<br>• Задлан шинжилдэг<br>• Шүүмжлэлтэй<br>• Хариуцлагатай<br>• Шударга<br>• Мэргэжлийн ур чадвартай<br>• Нээлттэй, ил тод<br>• Ажигч<br>• Төвийг сахих |
| 2 | Асуудал хариуцсан албан тушаалтан, хороо | Хүсэлтийг бүртгэх | | |
| | | Хүсэлтийг хянаж, үнэлэх | | |
| | | Лавлахад байгаа эмтэй үнэ, гаж нөлөө болон хэрэглээг нь харьцуулах | | |
| 3 | Хүсэлтийг холбогдох хороогоор хэлэлцүүлэх | Үр ашигтай болон аюулгүй байдал, үнэ үр ашгийн харьцуулсан үнэлгээ, зөвлөмжийг боловсруулах | | |
| | | Зөвлөмж гаргах | | |
| | | Холбогдох хороогоор хэлэлцүүлэх | | |
| | | Судалгааны эмнэлзүйн туршилтын арга зүйг батлах | | |
| 4 | Эмэн эмчилгээний хороо ба нотолгоонд үндэслэн шийдвэрлэх | Өвчлөлийн тархалт | | |
| | | Үр ашигтай болон аюулгүй байдлын талаарх нотолгоо | | |
| | | Үнэ-үр ашгийн харьцуулалт | | |
| | | Орон нутгийн хэлэлцүүлэг | | |
| | | Эмчилгээний байгууллага болон хувь хүний туршлага | | |
| | | Нотолгоонд суурилсан эмчилгээний зөвлөмжтэй холбох | | |
| | | Тоймлож эмхэтгэх | | |
| | | Эмчилгээний идэвхийн талаарх судалгааны дүн | | |

## 5.Худалдан авах ажиллагаа, түгээлт

Худалдан авах үйл явц нь чанарын шаардлага хангасан зөв эмийг, зөв тоо хэмжээгээр, боломжийн үнээр авахад чиглэгдэнэ.

| № | Үйл ажиллагаа | Үйл ажиллагааны үе шат | Өртөмтхий үзүүлэлт | Холбогдох ёс зүйн зарчим | Ёс зүйн алдаа гаргахаас сэргийлэх |
|---|---|---|---|---|---|
| 1 | Эмийн сонголтыг хянах | Худалдан авах эмийн хэлбэрийг шийдэх | • Ашиг сонирхолын зөрчил<br>• Хээл хахууль<br>• Хуйвалдаан<br>• Залилах<br>• Дарамт<br>• Үүрэг<br>• Залилах<br>• Дарамт<br>• Урамшуулал<br>• Хээл хахууль<br>• Ашиг сонирхолын зөрчил<br>• Хуйвалдаан<br>• Залилах | • Эрх тэгш байдал<br>• Үр ашигтай байх<br>• Цаг үеэ мэдэрсэн<br>• Найдвартай<br>• Мэдлэгтэй<br>• Ил тод<br>• Задлан шинжилдэг<br>• Шүүмжлэлтэй<br>• Хариуцлагатай<br>• Шударга<br>• Ашиг сонирхолын талаарх мэдлэг<br>• Өөртэй итгэлтэй<br>• Багаар ажилладаг | • Тодорхой нэг ханган нийлүүлэгчид бизнесийн нууц мэдээллийг өгөх<br>• Ханган нийлүүлэгчийн сонголтыг тодорхой нэг ханган нийлүүлэгч рүү чиглүүлэх<br>• Ханган нийлүүлэх явцдаа байнга алдаа гаргадаг ханган нийлүүлэгчийг сонгох<br>• Сонгох үйл ажиллагаа шаардлагагүйгээр удаашруулах<br>• Хэмжээг хэрэгцээнээс их эсвэл багаар тогтоох<br>• Нэг хүний шийдвэртүндэслэх<br>• Бодит хэрэгцээнээс зөрүүлж захиалах<br>• Чанарын шаардлага хангаагүй эмийг хүлээн авах |
| | | Худалдан авалт ЭМЯ-ны эмийн лавлахад орсон эмэн дээр үндэслэгдэх | | | |
| | | Бүртгэгдсэн бүтээгдэхүүнийг худалдан авах | | | |
| 2 | Худалдан авах хэрэгцээтэй тоо хэмжээг тогтоох | Эцсийн хэрэглэгчийн хэрэглээн дээр үндэслэн бодитой сонгох | | | |
| | | Эмийн эргэлтийн тогтмол хяналт, хэрэглээний загвар дээр үндэслэх | | | |
| 3 | Хэрэгцээ ба санхүүжилтийг уялдуулах | Худалдан авах ажиллагааг мөнгөн сангийн хүртээмж дээр үндэслэн хийх | | | |
| 4 | Худалдан авах ажиллагааны аргыг сонгох | Мөнгөн сангийн журмыг дагаж мөрдөх | | | |
| 5 | Ханган нийлүүлэгчийг сонгох | Сангийн Яаманд бүртгэлтэй ханган нийлүүлэгчдээс мөнгөн сангийн журам болон эргэлтэнд нийцүүлэн худалдан авах хязгаарыг тогтоож сонголтыг хийх | | | |
| 6 | Гэрээний нөхцлийг тодорхойлох | Ханган нийлүүлэгчтэй гэрээний заалт нөхцлийг зөвшилцөх | | | |
| 7 | Захиалга хийх | Сангийн хүртээмж, шаардлага дээр үндэслэх | | | |
| | | Чанар болон үнийг үндэслэж захиалга хийх | | | |
| 8 | Захиалгаа хянах | Тогтвортой хангалтыг бий болгохын тулд захиалгыг тогтмол хянах | | | |
| 9 | Эмийг хүлээж авах, шалгах | Гэрээний заалтыг биелүүлж байгаа эсэхийг барааг хүлээж авахдаа шалгах | | | |
| | | Барааг хүлээн авсны дараа тооллогын систем болон агуулахын бүртгэлд оруулах | | | |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| | | Падаан бүр дагалдах шинжилгээний сертификаттай байх | | | • Зохих баримт бичгийг бүрэн бүрдүүлсний дараа төлбөр төлөлтийг шаардлагагүйгээр удаашруулах<br>• Ашиг сонирхолын зөрчилтэй этгээдийг аудит хийлгэхээр томилох |
| 10 | Төлбөр төлөх | Төлбөрийг хангах нийлүүлэгчээс шаардаглах бичиг баримтыг бүрэн авсны дараа тогтоосон хугацаанд хийх | | | |
| 11 | Хэрэглээний мэдээллийг цуглуулах | Хэрэглээний мэдээлэлийг бүх эмийн барааны захиалга болон эцсийн хэрэглэгчийн үнэлэлт дээр тулгуурлан төлөвлөсөн хугацаанд цуглуулах | | | |
| 12 | Барааны ачилтыг тогтмол хянаж шалгах, аудит хийх | Мөнгөн сангийн журам, гэрээний заалтанд нийцсэн эсэхийг шалгах | | | |
| | | Барааны ачилтыг хянаж шалгах стандарт үйл ажиллагааны журмын дагуу хянах | | | |
| | | Хөндлөнгийн аудитор жилдээ нэгээс доошгүй удаа аудит хийх | | | |